



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2015 оны 12 сарын 04 өдөр

Дугаар 410

Улаанбаатар хот

Журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

"Банк бус санхүүгийн үйл ажиллагааны зохицуулалтын журам" шинэчлэн батлагдсантай холбогдуулан Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2, Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.4-т заасныг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Санхүүгийн зохицуулах хорооны 2014 оны 08 дугаар тогтоолоор батлагдсан "Хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн болон үйл ажиллагааны журам"-д дор дурдсан агуулгатай 2.3¹, 2.3². дахь хэсэг нэмсүгэй:

1/ Журмын 2.3¹. дахь хэсэг:

"Хорооноос тогтоосон журмын дагуу итгэлцэл, хөрөнгийн удирдлагын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан хуулийн этгээд нь уг тусгай зөвшөөрлийн хүрээнд энэхүү журамд заасан хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагааг хавсран эрхэлж болно."

2/ Журмын 2.3². дахь хэсэг:

"Энэхүү журмын 2.3¹ дахь хэсэгт заасан этгээдэд энэ журмын 2.2, 4.6, 7.1.17 дахь хэсэг хамаарахгүй."

2. Мөн журмын 4.3, 7.1.16 дахь хэсгийг тус тус хассугай.

3. Санхүүгийн зохицуулах хорооны 2014 оны 08 дугаар тогтоолоор батлагдсан "Хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн болон үйл ажиллагааны журам"-д өөрчлөлтийг оруулж, олон нийтэд мэдээлэхийг Тамгын газар /П.Алтан-Од/, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт шалгалтын газар /Б.Оюунцацрал/-д тус тус даалгасугай.

ДАРГА



З.НАРАНТУЯА

001082